



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Г ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОД  
АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА УДАШ ТАНАА

2024. 07. 19 № 498  
танай -ны № -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дорнод аймгийн Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Дорнод аймгийн Ардчилсан намын аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дорнод аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр арван долоон хуудас хавсаргав.

Хувийг: “Дорнод аймгийн Ардчилсан намын хороо”-нд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 17 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ „ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ДОРНОД АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЭХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.07.17

Хэрлэн сум

**Нэр:** ШИНЭ ДОРНОД

**Уриа:** “ЗОРИГТОЙ ӨӨРЧИЛЬЕ”

**Зорилго:** Улс, орон нутгийн эрх ашиг, хуулийг дээдлэн, хувь хүн, өрх гэр, сум, аймаг, бүсчилсэн хөгжлийг эрхэмлэж баялгийг бүтээгч иргэдийн амьдрах аюулгүй, ая тухтай амьдрах нөхцлийг хангах, дундаж орлоготой иргэдийг нэмэгдүүлж, Чойбалсан хотын шинэ бүтээн байгуулалт, эрчимтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

Хүрээлэн буй орчин нь тааламжтай, амьдралын чанараа тогтмол дээшлүүлэх нөхцөл бүрдсэн хотод эрүүл, боловсролтой, ирээдүйдээ урам зоригтой амьдрах боломжийг цогцлоох нь Хэрлэн сумын мөрийн хөтөлбөрийн хөгжлийн бодлогын зорилт байна.

Бүхий л бодлогын цөмд ИРГЭН байна. Иргэнд ээлтэй орчин, Иргэнд өгөөжтэй эдийн засаг, Иргэнд хүртээмжтэй боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, дэд бүтцийг бурдуулэхийн төлөө ажиллана.

**Хэрэгжих хугацаа:** 2024-2028

**Зорилт:**

1. АМГАЛАН, НАЙРСАГ ДОРНОД
2. АЮУЛГҮЙ, НОГООН ДОРНОД
3. АМЬЖИРГААТАЙ, ОРЛОГОТОЙ ДОРНОД
4. АЖИЛСАГ, БҮТЭЭЛЧ ДОРНОД
5. АРД ИРГЭДДЭЭ ЭЭЛТЭЙ ДОРНОД
6. АВЛИГАГҮЙ, АРДЧИЛСАН ДОРНОД

## НЭГ. АМГАЛАН, НАЙРСАГ ДОРНОД

- 1.1. Чойбалсан хотын болон сумдын иргэдийн санал санаачлагад тулгуурласан хүний аюулгүй, ая тухтай амгалан тайван амьдрахад чиглэсэн найрсаг, эрчимтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.2. Аймгийн төв болон сумдын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г шинэчлэн мөрдөж, төлөвлөлтгүй дур зоргын хөгжлийг таслан зогсоож гажуудлыг арилгана.
- 1.3. Сумдын төвийг хөгжүүлэх “Амгалан хөдөө” төслийг хэрэгжүүлнэ.
- 1.4. Чойбалсан хотыг улсын зэрэглэлтэй хот болгон өөрчилж зүүн бүсийн хөгжлийн төв болноно.
- 1.5. Хэрлэн голын урд “Шинэ - Ногоон Чойбалсан” хотыг бий болгох төлөвлөлтийг эхлүүлж, хотын хөгжлийн болон иргэдийн шинэ амьдралын хэв маягийг бий болгоно.
- 1.6. Одоогийн Чойбалсан хотын гэрэлтүүлэг, засмал зам, явган хүний болон дугуйн зам, ногоон байгууламж, тохилог орчиныг эрс сайжруулан хөгжлийн агуулга бүхий найрсаг ногоон хот болгоно.
- 1.7. Дорнод нутгийн алдартнууд, сод авьяастнуудыг алдаршуулах, соёлын үнэт өв, бахархлыг бий болгох “Уран бүтээлчдийн цэцэрлэгт хүрээлэн”-г аймгийн төвд байгуулна.
- 1.8. Барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.
- 1.9. Дугуйн болон гүйтл, явган алхалтын замын сүлжээг нэмэрнуулж, мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэнэ.
- 1.10. Авто замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, зогсоолын хүрэлцээг шийднэ.
- 1.11. Залуу гэр бүл, ахмадууд, зорилтот бүлгийн иргэдэд зориулсан орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлж эхэнэ.
- 1.12. Хувийн орон сууц, хашааны зориулалтын хямд төсөр, чанартай, сонголт өргөнтэй материал үйлдвэрлэлийг бүх талаар дэмжинэ. Хашаандaa амины тохилог орон сууц барих санаачилгыг бодлогоор дэмжинэ.
- 1.13. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдуулсан амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- 1.14. Хот, хөдөөгийн болон гэр хорооллын иргэдийг хувийн орон сууцтай болгох чиглэлээр бүтээн байгуулалт хийх хувийн хэвлэлийг дэмжинэ.
- 1.15. Буриад түүх, өв соёлын музейн ажлыг дуусгах, Барга, Үзэмчиний түүх, өв соёлын олон улсын төв байгуулах ажлыг дэмжинэ.

## ХОЁР. АЮУЛГҮЙ, НОГООН ДОРНОД

- 2.1. Дорнод бүс нутаг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өөрийн орны онцлогийг харгадзан хөгжлийн замаа тодорхойлохдоо байгаль орчинд ээлтэй ногоон хөгжил, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг хангана.
- 2.2. Дорнод Монголын талын экосистемийн унаган төрхийг хадгалах, сэргээх хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.3. Орчноо ногоон байгууламжтай болгосон, иргэдийг сургаж, мэргэшүүлсэн, ажлын байр бий болгосон иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.4. Чойбалсан хотын нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууцны орчныг зүлэгжүүлж моджуулах “Ногоон байгууламж” хөтөлбөрийг байгууллага, аж ахуйн нэгж, СӨХ, хувийн хэвшил, иргэдийн бүлэг, нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.

- 2.5. Уурхайн үйл ажиллагааны хяналт, нөхөн сэргээлт, хаалтын стандартыг олон улсын жишигт хүргэж, дүйцүүлсэн нөхөн сэргээлтийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулж хэрэгжүүлнэ.
- 2.6. Хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу нөхөн сэргээлт, хаалтын асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрэн хариуцан гүйцэтгэдэг болгоно. Нөхөн сэргээлтийг орон нутгийн мэргэшсэн компани, нэгжүүдээр гүйцэтгүүлэхийг дэмжинэ.
- 2.7. ХАА-н хөгжлийн суурь хүчин зүйл болсон бэлчээр, хөрсийг хамгаалах, зохистой ашиглах эрх зүйн орчныг шинэчилэхэд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаар дамжуулан идэвхтэй оролцох, бүх төрлийн ажил үйлчилгээний зөвшөөрөл олгоходо байгаль орчин, эко бүтцийг хамгаалах, нөхөн сэргээх шалгуурыг нэгдүгээрт тавьдаг журмыг хэрэгжүүлнэ.
- 2.8. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн 30-аас доошгүй хувийг сэргээнэ.
- 2.9. Хадлан, тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээхэд тариаланчид, хадланчдын болон төрийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлнэ.
- 2.10. Газар тариаланд ус, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй техник, технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжиж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.11. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулах, хэрэгцээг хүртээмжтэй хангах санаачилгыг дэмжинэ.
- 2.12. Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг хэмнэлтийг сайжруулна. Усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамааран шатлан өсгөх зарчимд суурилан тогтооно.
- 2.13. Аймгийн болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, газрын доорх усны нөөц баялгийг бүртгэлжүүлж, ашиглалтын зохистой менежмент явуулах, усны нөөцийн өөрчлөлт, ашиглалтын талаарх бодит мэдээллийг бий болгох зорилгоор гадаргын усны харуулын тоо, газрын доорх усны хэмжилтийн цэг, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг нэмэгдүүлэн өргөтгөж, худаг уст цэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, шаардлага хангасан үндны усаар аймаг, сумын төвийн иргэдийг бүрэн хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.14. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг үе шаттай зохион байгуулж, нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Олон талт байгаль хамгааллын менежмент, техник, технологийн хөгжлийг нэвтрүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигтай байдлыг сайжруулна.
- 2.15. Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.16. Хог хаягдлын төвлөрсөн цагийн байршлыг оновчтой тогтоож, стандартын ландфиллын болон аюултай хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулна.
- 2.17. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, боловсруулах ЗР цогц менежментийг хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин ашиглах, боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвцэлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.18. Ойг нөхөн сэргээх, ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн хамгаалалтын зурvas байгуулах арга хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.19. Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ой, раашаан, булгийг хамгаалах чиглэлээр өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах хөтөлбөр хэрэгжүүлж, олон улсын байгуулагуудтай хамтран ажиллана.
- 2.20. Дорнод нутгийн байгаль, экологийн онцлогийг тусгасан, хүүхэд залуучуудын эко аялал, судлагааны хөтөлбөр бий болгож хэрэгжүүлэх санаачилга гаргасан боловсролын болон олон нийтийн байгууллагуудыг дэмжинэ.
- 2.21. Дорнод талын цагаан зээрийг хамгаалах үйл ажиллагааг идэвхижүүлнэ.
- 2.22. Байгальд ээлтэй, үр ашигтай дэвшилтэй технологи нэвтрүүлж, хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, гүний ус, байгалийн нөөцийг хэмнэх, хаягдалгүй эдийн засгийг /circular economy/

- хөгжүүлэх бүх төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалт, хайгуул, олборлолтын тэргүүлэх зорилтыг дэмжинэ.
- 2.23. Дэлхийн цаг уурын өөрчлөлтөд хөдөөгийн иргэдийг дасан зохицуулах менежментийг сайжруулна.
- 2.24. Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхид сууриссан менежментийг нэвтрүүлнэ.
- 2.25. Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг нутгийн иргэдийн оролцоонд түшиглэн цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлэх, ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг төсвөөс дэмжинэ.
- 2.26. Байгаль орчны хуулийг зөрчсөн аж ахуйн нэгжийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг цушиах, цаашид олгохгүй байх бодлого баримтлана
- 2.27. Уул уурхайн нөхөн сэргээлт хийлгүй орхисон аж ахуй нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд оногдуулах хариуцлага, ял шийтгэлийг эрүүгийн хуулиар чангатгахыг дэмжинэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх багийг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүд өөрөө сонгодог нь сонирхлын зөрчил үүсгэж буй тогтолцоог өөрчилж, хуулийг боловсронгуй болгохыг дэмжинэ.
- 2.28. Мэнэнгийн талын экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.29. Чойбалсан хотыг камержуулж, цагдаагийн байгууллагатай шууд, хялбар байдлаар холбогдох тоноглол бүхий “ногоон бүс” буюу аюулгүй бүс бий болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.30. Хүнсний зах, бөөний худалдаанд мөрдөгдөг ариун цэвэр, аюулгүй байдлын стандартыг шинэчилж, мөрдүүлнэ.
- 2.31. “Ариун цэврийн үйлчилгээний цэг” стандарт хөтөлбөрийг тухайн газарт үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц болон худалдаа, үйлчилгээний объектуудад санал болгож, хамтран хэрэгжүүлнэ.
- 2.32. Гэр хорооллын агаар, хөрсний бохирдлыг зогсоох чадамж бүхий хэсэгчилсэн инженер хангамжийн дэд бүтэц болон хашаандaa амины орон сууц барих боломж нөхцлийг бүрдүүлэх, дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.33. Чойбалсан хотыг агаарын бохирдолгүй, эрүүл, цэвэр ногоон хот болгох чиглэлийг хариуцсан ОНӨҮГ байгуулж ажиллуулна.
- 2.34. Хог, орчны бохирдлын эсрэг шинэчилсэн менежмэент хэрэгжүүлж, иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг оролцоог тодорхой болгож, “Хоггүй Чойбалсан хот” зорилтот үйл явцыг хэвшүүлж, үр дүнд хүргэнэ.
- 2.35. Чойбалсан хот доторхи замын сулжээг зогсоол, аюулгүйн тойрог, үерийн ус зайлцуулах байгууламж, гэрлэн дохио, явган болон дугуйн замын бүрдэл, аюулгүйн тэмдэгжүүлэлтийн хамт орчин үеийн технологи, стандарт, бүтэц зохион байгуулалтаар шийдвэрлэж, замын нөхцлөөс болж иргэд эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөөр хохирдог шалтгааныг таслан зогсооход онцгой анхаарна.
- 2.36. Хот дотор барилга барих зөвшөөрлийг хэсэгчилсэн дахин төлөвлөлт, ногоон бүс, чөлөөт цагийн орчны шаардлагад нийцүүлж олгох журмыг хэвшүүлнэ.
- 2.37. Нийтийн эзэмшилийн газар болон иргэдийн амьдрах, зорчих орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй барилга, байгууламж, хашааны үнэлгээг хийж, газар чөлөөлөх нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.38. Иргэний аюулгүй, эрүүл орчинд амьдрах эрхийг баталгаажуулах хүрээнд нийтийн орон сууц, сургууль, цэцэрлэг, гэр хороололтой ойрхон шатахуун түгээх станц болон хийн түлшний түгээгүүр байгуулахыг хориглоно.
- 2.39. Чойбалсан сумын нутагт орших Хоёр Мэлхий нуурын усны эргэлтийг Хэрлэн голын үерийн усыг тогтоох усны тохируулга хийж, усан сан үүсгэн загас, нүүдлийн шувуу саатах эко систем бий болгоно.

## ГУРАВ. АМЬЖИРГААТАЙ, ОРЛОГОТОЙ ДОРНОД

- 3.1. Иргэдээс эзэмшихээр хүсэлт гаргаж буй хүнсний ногоо, малын тэжээл, мод, зүлэг үржүүлэг, хүлэмж, жимсний аж ахуй, ХАА-н сургалт дадлагын төв, агропарк, хоршоо, фермер, зоорийн зориулалтаар ашиглах газруудыг олгоход дэмжлэг үзүүлнэ.

- 3.2. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол өсгөх, халамж шаардлагатай гэр бүлийн гишүүнд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанарыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.
- 3.3. Ахмад настнуудын нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өндөр настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэхэд төр засаг, олон нийтийн байгууллага, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгжүүд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.4. Өрхийг тогтмол орлоготой болгох, уламжлалт бренд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор сум, аймгийн төвийн багуудын онцлогт тохирсон “Нэг өрх-нэг төсөл” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.5. Хүүхэд харах үйлчилгээг сэргээнэ.
- 3.6. “Иргэний томилолт”-ыг бий болгоно. Гадаад, дотоодын хөгжлийн сайн туршилгыг олж мэдэх, хөгжилд чиглүүлэх, ашиглах зорилгоор иргэдийг “Иргэнэй томилолт” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.7. Орон нутагт хөдөлмөрийн зах зээлийн судалгааг мэргэжлийн түвшинд хийдэг өөрийн онцлог, нөөц боломж, давуу талаа ашиглан эдийн засгийн өсөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлэх чадавхитай болгоно.
- 3.8. Нэн тэргүүнд бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн, ажлын байрны шингээлт ихтэй жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд, ХАА-н гаралтай түүхий эд боловсруулах хөнгөн үйлдвэрүүдийг дэмжиж замаар ажлын байрны хүлээгдэж буй эрэлтийг хангаж, ажлын байр, орлогыг нэмэгдүүлнэ.
- 3.9. Цагийн ажлын тогтолцоог дэмжсэн хөдөлмөр зуучийн үйлчилгээг дэмжинэ.
- 3.10. Малчдын даатгалыг өргөжүүлж, зээлийн хэмжээг нэмэгдүүлж хүүг бууруулж, тэдний нийгмийн баталгааг хангахыг дэмжинэ.
- 3.11. Цагаар, гэрээр, зайнаас ажиллах, гэрээгээр бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжиж, эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.12. Өмчлөлийн газар дээрээ аж ахуй эрхлэх, амьдрах орчноо сайжруулах, гэр хорооллын зохион байгуулалт, тохижилтыг оновчтой болгох хүсэлтэй иргэд, гэр бүлийн санаачилга, хөдөлгөөнүүдийг зээл, төслөөр дэмжинэ.
- 3.13. Сум бүрт хадлан, хүнсний ногооны орчин үеийн техник, тоног төхөөрөмж бүхий, орон нутгийн өмчit агротехникийн паркуудыг байгуулж, иргэдэд туслах үйлчилгээ үзүүлнэ.
- 3.14. Гарааны бизнесийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээг нэмэгдүүлж, инноваци, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн үйл ажиллагаа эрхлэх залуучуудыг дэмжинэ.
- 3.15. Зүүн бүсийн нийгмийн гол үйлчилгээ төвлөрсөн Дорнод аймгийн эрүүл мэнд, боловсролын салбарын ажилтнуудын цалин орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажил үйлчилгээний орчныг сайжруулах, хүний нөөцийн хүргээмж, чадавхийг дээшлүүлэх зорилгоор “Нийгмийн хамгааллын тэгш хөгжил” хөтөлбөрийг боловсруулж, сангийн эх үүсвэрийг Засгийн газрын дэмжлэгтэйгээр бүрдүүлж, хамтран хэрэгжүүлнэ.
- 3.16. Хотын хөдөлгөөн ихтэй газруудад шугам сүлжээн холбогдсон жорлонгууд нээн ажиллуулж хотын соёл нэвтрүүлнэ.

#### **ДӨРӨВ. АЖИЛСАГ БҮТЭЭЛЧ ДОРНОД**

- 4.1. Ашигт малтмалын ордын үндсэн болон дагалдах эрдсүүдийг иж бүрнээр ялган тодорхойлох авах, үйлдвэрийн хаягдал боловсруулах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- 4.2. Хэрэглээний халуун, хүйтэн ус, дулаан, цахилгаан түгээх болон нийлүүлэх ажлыг гүйцэтгэж буй төрийн өмчit компаниудад менежментийн шинэчлэлт хийж, томоохон хөрөнгө оруулалтыг шийдэх замаар хуучин дэд бүтцийн шугам, хоолойг шинэчилэх, засварлаж өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлж, хүн амын хэрэглээний цэвэр усны стандартыг хангана.

- 4.3. Нийтийн аж ахуйн нэгжийн хяналтад зориулагдсан ус, тог, дулааны зардлыг хэмжих автоматжуулалтын нэгдсэн систем нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.4. Тухайн бүс нутгийн аймаг, хотууд хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбараа тодорхойлж, хөгжлийн бодлогоо уялдуулан бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ хил залгаа аймаг болон хөрш улсуудын зах зээлийн нөхцөл, дотоодын үйлдвэрлэлийн чадавхи, дэд бүтцийн боломжид тулгуурлан дэд бүтцийн томоохон барилга, байгууламж, тээвэр, логистикийн сүлжээг бий болгох, бүсийн дэд бүтцийн тэнхлэгийн үндсэн сүлжээг байгуулж, зүүн хойд Азийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлэхэд онцгой анхаарна.
- 4.5. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг үргэлжлүүлж, бүх сумдыг хамруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
- 4.6. Сэргээгдэх эрчим хүчний дэд бүтэц, цэвэр эрчим хүчний технологид оруулах хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 4.7. Чойбалсан хотын цахилгаан шугам сүлжээг 35кВ -ын гадна цагираг схемээр тэжээж хотын захаар үйлдвэрлэл хөгжих боломжтой цахилгаан хангамжийн найдвартай алдагдалтүй систем үүсгэнэ
- 4.8. Сумдын цахилгаан эрчим хүчний дэд станцуудыг өргөтгөх, цахилгаан дамжуулах агаарын шугамуудын насылтыг тодорхойлж, шинэчилэх ажлыг дэмжинэ.
- 4.9. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн хөндлөн тэнхлэгийн гол шугамд холбогдох Чойбалсан-Чингис-Багануурын 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж байгуулах ажлыг хийж дуусгана.
- 4.10. Ногоон технологид суурилсан хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалын зохистой хослол бүхий бүс нутаг болон хөгжих урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд хүчин чармайлтад нэгтгэж ажиллана.
- 4.11. Хилийн боомт чиглэсэн авто зам, төмөр замуудыг ашиглалтад оруулж, боомтуудыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилж, олон улсын зэрэглэлтэй болгох, бүс дамнасан тээвэр логистикийн сүлжээнд холбогдох төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, хөрш улсуудтай хийх худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. /Эрээнцав, Сүмбэр, Ульхан, Хавирга, Баянхшуу, Бичигт хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилэнэ. Дорнод аймгийн нисэх онгоцны буудлыг агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай, байнтгын ажиллагаатай олон улсын боомт болгох хөрөнгө оруулалтын ажлыг шийдэхэд бүх талаар анхаарч ажиллана.
- 4.12. Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод үе шаттай хэрэгжүүлэхээр заагдсан Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн зам, тээврийн төслүүд болох Чойбалсан-Баруун-Уртын 190 км, Матад-Хөөт-Баруун-Урт-Сайншандын 470, Чойбалсан-Ульхан боомтын 223.48, Чойбалсан-Хавирга боомтын 124.8, Чойбалсан-Эрээнцав боомтын 124.8, Чойбалсан-Сүмбэрийн 410, Чойбалсан-Ульханы 228, Бичигт-Баруун-Урт-Чойбалсан-Эрээнцавын 715 км авто зам, жижиг дунд оврын гүүр, Чойбалсан тээвэр логистикийн төв байгуулах зэрэг арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэхэд санаачилга гаргана.
- 4.13. Чойбалсан-Хөөт-Бичигтийн 414, Хөөт-Сүмбэрийн 380, Эрээнцав-Хөөт-Бичигтийн хос, цахилгаан төмөр замыг барих ажлыг эхлүүлэх, Чойбалсан хотын төмөр замын сүлжээг ашиглан төмөр замын ложистик төв байгуулахад хүч чармайлтад нэгтгэж ажиллана.
- 4.14. Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратеги, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг хамтран гүйцэтгэнэ.
- 4.15. Бүсийн их, дээд сургууль, мэргэжлийн сургуулиудын судлагаа, эрдэм шинжилгээ, сургалтын орчныг сайжруулахад анхаарна.
- 4.16. Дорнод Монголын талын эко системд зохицсон бэлчээрийн мал аж ахуйг бодлогоор хөгжүүлэхийг МАА-н салбарын тэргүүлэх зорилт болгоно.
- 4.17. ХАА-д нэн тохиромжтой зүүн бүсийг ХАА-н үйлдвэрлэлийн бүс нутаг болгох зорилгоор зүүн бүсийн ХАА-н эрдэм шинжилгээ, судлагаа, мэдээлэл, технологид суурилсан, тус бүс нутгийн онцлогт

- тохирсон, экспортод чиглэсэн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн сүлжээг хөгжүүлэхэд идэвх чармайлттай оролцно.
- 4.18.Уур амьсгалын өөрчлөлт, Дорнод Монголын талын эко системд дасан зохицсон шилмэл омгийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нэмэгдүүлэн, бэлчээрийн мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан хөгжүүлсэн, малын өвчингүй эрүүл, халдвартгүй бүс нутаг болох арга хэмжээг туштай хэрэгжүүлнэ.
- 4.19.Аймаг, бүс дундын хадлан, отрын нөөц газруудыг өргөтгөж, хадлан, тэжээлийн үйлдвэрлэл эрхэлж, бүсийн хэрэгцээг хангах аж ахуйн нэгж, иргэдийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 4.20.Чойбалсан хотод байгуулагдсан Зүүн бүсийн хөдөө аж ахуйн паркийн үйл ажиллагааг бүх талаар дэмжинэ.
- 4.21.Бүсчилсэн байдлаар мах хөргөлтийн агуулах зоорь, сумдад малын түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжиж ажиллана.
- 4.22.Барилгын материалын үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.23.Чойбалсан хотын түүхэн дурсгалуудыг сэргээн засварлах, хамгаалах, хаягжуулах ажлыг гүйцэтгэх, Халхголын түүхэн дурсгалт газруудтай нэгдсэн аялал жуулчлалын маршрут бий болгоно.
- 4.24.Дорнод аймагт Дорнод Монголын тал хээрийн шим мандлын өвөрмөц экосистем, Халх гол-Буйр нуурыг түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалыг, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- 4.25.Түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлалын хүрээнд орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор Чингис хааны Хар сүлдний болон Өүлэн хатны түүхэн цогцолбор байгуулах санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 4.26.Орон нутгийн иргэдийн амьдралд нөлөөтэй, жуулчдал чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 4.27.Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, Монголын түүхэн аялал жуулчлалын төв бүс болох үйл ажиллагааг эрчимжүүлнэ
- 4.28.Аялал жуулчлалын талаар баримтлах төрийн болон орон нутгийн бодлогын нэгдмэл байдал, бүтэц, зохион байгуулалтыг хангаж, олон улсын стандартыг нэвтрүүлэх, салбарын хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг бүх чиглэлээр дэмжиж ажиллана.
- 4.29.Аймгийн төвийн болон сумдын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлцуулах шугам сүлжээний ажлыг стандартын дагуу хийж хэрэгжүүлнэ.
- 4.30.Сумдын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, хэрэгжүүлж эхэлнэ.
- 4.31.Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн, бие даасан инженерийн хангамжид холбох, бичил дэд төвүүдийг байгуулах төслийг дэмжинэ.
- 4.32.Чойбалсан хотын дулаан хангамжийн багтаамж 2 дахин өссөнтэй холбоотойгоор дулааны шугам сүлжээг өргөтгэн төвлөрсөн дулаан хангамжид хэрэглэгчдийг холбоно.
- 4.33.Улаанбаатар-Чойбалсан чиглэлийн авто замын 380-430 километр дахь 50 км зам, Булган сумын нутаг дахь 30 км эвдрэлтэй замыг яаралтай бүрэн засварлуулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.
- 4.34.Чойбалсан хотын доторхи босоо, хэвтээ чиглэлийн стандарт бус авто зам, уулзваруудыг шинэчлэн засах, цаашид хотын доторх зам засварын болон ногоон байгууламж, авто машины зогсоол, гүйт, дугуй, явган замыг өргөжүүлэх ажлыг хариуцаж, бие даан хийх хүчин чадалтай орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулж, орчин үеийн шаардлагатай техникийн хангах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийднэ.
- 4.35.Чойбалсан хотоос урагш Хэрлэн гол дээгүүр орчин үеийн шийдэл бүхий хүнд даацын бетон гүүр барьж, хот тэлж хөгжих, зорчих хөдөлгөөний боломжийг нэмэгдүүлнэ.
- 4.36.Чойбалсан хотын цэвэр усны шугамыг шинэчилж, ундны усны хангамж, чанарыг сайжруулах төслийг хэрэгжүүлнэ.

- 4.37. Чойбалсан хотын нутаг дэвсгэрийн зарим хэсэгт яаралтай хийх шаардлагатай байгаа “Ивээл” хороолол, Бунхан толгойн арын хэсэг зэрэг газруудад хэсэгчилсэн дахин төлөвлөлтийг хэрэгжүүлж, хот төлөвлөлтийн хэсэгчилсэн дахин төлөвлөлтийн жишгийг бий болгоно.
- 4.38. Дорнод бүсийн ХАА-н эрдэм шинжилгээний хүрээлэнг өргөтгөн байгуулж, зүүн бүсийн онцлогт тохирсон ХАА-г хөгжүүлэх, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах бодлогыг Засгийн газрын болон орон нутгийн хөтөлбөр болгон хэрэгжүүлэх санаачилгыг гаргана.
- 4.39. Сумдын цахилгаан эрчим хүчний дэд станцуудыг өргөтгөх, цахилгаан дамжуулах агаарын шугамуудын наслжилтыг тодорхойлж, өргөтгөн шинэчилнэ.

## ТАВ. АРД ИРГЭДДЭЭ ЭЭЛТЭЙ ДОРНОД

- 5.1 Их, дээд сургууль, мэргэжлийн сургууль-үйлдвэрийн түншлэлээр мэдлэгт суурилсан нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, нийгэмд тулгарч буй асуудлыг хамтран судлаж, шинжлэх ухааны үндэстэй шийдвэрлэх салбар дундын гэрээ, хөтөлбөр боловсруулж ажиллахыг бүх талаар дэмжинэ.
- 5.2 Их, дээд сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа, R&D чиглэлийн үйл ажиллагааг дэмжинэ.
- 5.3 Бага насын хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг орон нутагтаа эрт илрүүлэх оношлох, хүүхэд бүрт тохирох шаардлагатай сэргээн засах хөгжлийн үйлчилгээ үзүүлэх чадавхийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
- 5.4 Багш нарыг дэлхийн нэр хүндтэй их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт суралцахад бүх талаар дэмжлэг үзүүлнэ.
- 5.5 Багшийн хөдөлмөрийн үнэлэмж, нийгмийн баталгааг сайжруулах, амжилтыг үнэлэхдээ ялгавартай ханддагийг зогсоож, тэгш хамрагдах боломжийг хангасан зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.6 Дорнод нутгийн ирээдүйн хөгжил, шинэчлэлд шаардлагатай мэргэжлээр жил бүр 100-гаас доошгүй залуусыг олон улсад магадлан итгэмжлэгдсэн, дэлхийн шилдэг их, дээд сургуульд сургах, мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх “Дэлхийн боловсролыг тал нутагтаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.7 Их, дээд сургууль, MCYT, ЕБС-ийг тухайн орон нутаг, бүс нутгийн хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж, бүх насын иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоотой болгож бэхжүүлнэ.
- 5.8 Сургуулийн насын хүн амын тооны өсөлтөд тулгуурлан бүх шатны сургалтын байгууллагын дэд бүтцийг сайжруулан, орчин үеийн стандарт, чанарын шаардлага хангасан, багш нар бие дааж мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх боломж бүхий тэгш, хүртээмжтэй орчин бүрдүүлнэ. Энэ хүрээнд аймаг, сумын төвийн ЕБС-иудыг нэг зэлжтэй болгох бүх нөөцийг ашиглаж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- 5.9 Сургууль, цэцэрлэгийн дэд бүтэц, хүүхэд сургуульдаа аюулгүй ирж буцах, эрүүл, чөлөөтэй хөгжиж суралцах орчны стандартыг хэрэгжүүлнэ.
- 5.10 Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр ТББ, хувийн хэвшилтэй идэвхтэй хамтран ажиллана.
- 5.11 Дотуур байрны орчин, нөхцлийг сайжруулах, ялангуяа сургуульд элсэн орж буй бага насын хүүхдийн бие даан амьдарч суралцах боломжийг хангах төслийг олон улсын байгууллага, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 5.12 “Үдийн хоол” хөтөлбөрийн хүнсний аюулгүй байдлын хяналт, бүтээгдэхүүний нийлүүлэлт, чанар, хүртээмжийг сайжруулж, бага ангийн хүүхдүүдэд “Үдийн сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.13 Хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийн орчныг гэр хороолол, орон сууцны газар зохион байгуулалт, төлөвлөлтөд тусгаж, тоног төхөөрөмж, хэрэгслүүдийн чанар, стандартын шаардлагыг өндөржүүлнэ.
- 5.14 Хүүхдийн чөлөөт цаг, хөгжлийн орчныг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх хувийн хэвшлийн санаачилгыг нэн тэргүүнд дэмжинэ.

- 5.15 Хүүхдийн авьяас чадварыг нээх, чөлөөт цагаараа сонирхсон чиглэлээр оюун ухаан, бие бялдраа хөгжүүлэх, багш нарын сургалтын ур чадварыг дээшлүүлэх боломжийг тэгш хангасан, орчин үеийн тэргүүлэх орчин бүхий “Авьяас” нэгдсэн цогцолборыг байгуулна.
- 5.16 Сургуулийн өмнөх боловсролыг бага насын хүүхдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор цэцэрлэгийн барилга, байгууламж, хүүхдийн орны тоог эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үе шаттай нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг норматив, орчны стандартын дагуу хүүхдэд бүрт ээлтэй, эрүүл, аюулгүй орчинг бий болгоно.
- 5.17 Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 1-3, 4-5 настай хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээг үндэслэн төсвийг төрөөс бүрэн хариуцаж санхүүжүүлэх, хүүхдийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд тавих мэргэжлийн болон лабораторийн хяналтыг тогтмолжуулна.
- 5.18 Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулж, Дорнод Их сургууль, Политехник коллежид шинэ анги нээж, мэргэжил олгохыг дэмжиж өргөжүүлэх, тухайн сургуулиудын эрдэм шинжилгээ, судлагааны ажлыг бүсийн хөгжлийн төлөвлөлттэй уялдуулж хөгжүүлнэ.
- 5.19 Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцийг тогтвржуулах зорилгоор цэцэрлэг, ЕБС-ийн багш, туслах багшийн ажлын ачааллыг ажлын байр, хөдөлмөрийн онцлогтой уялдуулж шинэчлэх, үйл ажиллагааны үнэлгээг тодорхой болгож, бодит цалинг өнөөдрийн хэрэглээний түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэхийг дэмжинэ.
- 5.20 Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчилж, багш өөрөө санаачилгаар, ажиллах явцдаа тасралтгүй хөгжих тогтолцоо, орон нутгийн орчинг бэхжүүлнэ.
- 5.21 Суралцагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, мэргэжлээ зөв сонгож ирээдүйгээ төлөвлөхөд нь зөвлөж туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйн мэргэжилтнийг сургууль бүрт ажиллуулахыг дэмжинэ.
- 5.22 Дэлхий, олон улс, улс, бүс, аймгийн түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад уралдаан тэмцээнд оролцож амжилт үзүүлсэн суралцагч, багш, сургуулийг дэмжих мөнгөн урамшууллын хэмжээг тогтоож мөрдүүлнэ.
- 5.23 Боловсролын өмнө тулгамдсан асуудал, хүний нөөцийн чадварт суурилсан мерит зарчмаар албан тушаал, мэргэжлийн хөгжлөө тодорхойлох, салбарын хүний нөөцийн шаардлагыг хангах тогтолцоог бий болгож, боловсролын шат шатны удирдлагыг улс төрийн томилгоонос хараат бус болгоно.
- 5.24 Боловсролын нийгмийн хамгаалын тогтолцоог бэхжүүлж, сургалтын төлбөр гэр бүлийн амьжиргааны түвшинд хүндэрэд учруулдаг, ядууралд оруулдаг нөлөөг эрс бууруулах, суралцагчдын санхүүгийн хэрэгцээг олон хэлбэрээр шийдэх тогтолцоог дэмжинэ.
- 5.25 Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сургууль, цэцэрлэг бүрт хүргэж эрчимжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.
- 5.26 Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, хэрэглэж хэвших, нээлттэй боловсролын тогтолцооны нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах албан бус боловсролын тогтолцоог дэмжинэ.
- 5.27 Үндэстэн, ястны уламжлал, үнэт зүйлийг дээдэлсэн тайз, дэлгэцийн бүтээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 5.28 Спорт цогцолбор, сургалтын төв, чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлэх багтаамж ихтэй байгууламж, дэд бүтцийг бий болгох төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргана.
- 5.29 Спорт, урлагийн олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлнэ.
- 5.30 Уран зохиолын шүүмж судал, кино, жүжгийн зохиолын төрлүүдийг дэмжиж, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.
- 5.31 Ном, музейн салбаруудын орчин, шинэлэг санаачилгуудыг дэмжинэ.
- 5.32 Урлаг, соёл, уран зохиолын бүтээлийн үнэлэмж, эдийн засгийн баталгааг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

- 5.33 Үндэсний соёлын үнэт өв болох хурдан морь, сур харваа, үндэсний бөхийн амжилтыг үнэлэх, хөгжлийн шаардлагатай орчин нөхцлөөр хангахад онцгой анхаарна.
- 5.34 Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсын зах зээлд гарахад бодлогоор дэмжинэ.
- 5.35 Археологийн болон түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл, ангиллыг шинэчилж, соёлын өвийг хамгаалагч, харгалзагчтай байх тогтолцоог орон нутагт бий болгоно.
- 5.36 Бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин соёл, урлагийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлж, эдийн засгийн бодит салбар болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 5.37 Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэх, иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн /нийтийн эрүүл мэнд/ тогтолцоог хөгжүүлэхийг дэмжинэ.
- 5.38 Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдлийн шалтгааныг оношлох, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэхэд тэргүүн ээлжинд анхаарч, иргэд тогтсон хугацаанд үзлэгт орж, зөвлөлгөө авдаг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг олон улсын жишгээр үзүүлдэг нийгмийн эрүүл мэндийн загвар төв байгуулахыг дэмжинэ.
- 5.39 Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.
- 5.40 Ковидийн сургамжид үндэслэн халдварт өвчин, байгалийн гамшиг, онцгой нөхцлийн үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авна. Ковидийн дараах үеийн нөхөн сэргээлт, зөвлөмж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 5.41 Орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо, иргэд эх орондоо цогц оношлуулж, эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийг бүх талаар дэмжиж ажиллана.
- 5.42 Монголын уламжлалт анагаах ухаан, нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг хувийн эмнэлгүүдийн хөгжлийг дэмжинэ.
- 5.43 Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, импорт, түгээлт, үнийн цахим хяналтын тогтолцоог орон нутагт бий болгоход хүчин чармайлт гаргана.
- 5.44 Алслагдмал сум орон нутаг, хот сууринд амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусlamж, үйлчилгээний хүртээмж, чанарыг ижил түвшинд хүргэхүйц цахим эрүүл мэндийн системд шилжихэд шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлнэ.
- 5.45 Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах орон нутгийн хөтөлбөр боловсруулж, үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээ авна.
- 5.46 Хүн амд эрүүл аж төрөл, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, дадлагын хичээл тогтмолжуулах, эрүүл зөв дадал, хэвшил эзэмшүүлэх багш, мэргэжилтэн, сургагч багш нарыг бэлтгэхэд онцгой анхаарна.
- 5.47 Сум, баг бүрт эрүүл зөв хооллох, стрессээ тайлах, хөдөлгөөний хомсдооос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дастал хөдөлгөөн, иог, бүжгийн цогц үйлчилгээ үзүүлэх боломж бүхий “Эрүүл амьдрал” төвүүд ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 5.48 Архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөхөд анхаарна.
- 5.49 Өвдөхөөс өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, хяналтыг өрх гэрийн түвшинд хийх үйлчилгээг өргөтгөх, нийтийг хамарсан халдварт өвчнийг анхан шатанд илрүүлэн оношлох, эмчлэх чадавхийг бэхжүүлэх зорилгоор өрхийн эмнэлгүүдийг өргөтгэн бэхжүүлэх ажлыг дэмжиж ажиллана.
- 5.50 Орон сууц худалдан авах, өөрийн өмчлөлийн газартай инженерийн хангамж бүхий амины орон сууц барих, орон сууц түрээслэн амьдрах хэрэгцээтай өрх, бага, дунд орлоготой болон зорилтот бүлгийн иргэдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, шаардлагатай газарт хэсэгчилсэн дахин төлөвлөлт, зохицуулалт хийж орон сууцжуулах ажлыг зохион байгуулна.

- 5.51 Хүүхэд, залуучуудын авьяас чадварыг хөгжүүлэх, багш нарын ур чадвар, бүтээлч сэтгэлгээг дэмжих цогцолбор төв-ордон байгуулахыг дэмжинэ.
- 5.52 Нийгмийн сэтгээцийн эрүүл мэндийг хамгаалах бүсийн төвийг Дорнод аймагт байгуулахыг дэмжинэ.
- 5.53 БОЭТ-ийн эрсдэлийн хүч чадлыг нэмэгдүүлж, байгалийн гамшиг, халдварт өвчний үед хүн амын 5 хүртэлх хувийг тусгаарлан эмчлэх орчин, хүний нөөц, техник хэрэгслэлээр хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.54 Залуучуудын бие даасан амьдрал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүйн хөгжлийн хэрэгцээг дэмжих “Залуу гэр бүл” урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.55 Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхийн ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангах, ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголтой болгох, цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнлас ажиллах чиглэлээр санаачилга гаргаж, хөрөнгө оруулалт хийсэн хувийн хэвшлийг урамшуулах, тодорхой хөнгөлөлтөөр дэмжих бодлогыг эрх зүйн хүрээнд болон орон нутгийн хэмжээнд бий болгож хэрэгжүүлнэ.

### **ЗУРГАА. АВИЛГАГҮЙ АРДЧИЛСАН ДОРНОД**

- 6.1. Авилга хүнд суртал ашиг сонирхолын зөрчилтэй хийх тэмцэлд эрс щинэчлэл гаргана.
- 6.2. Орон нутгийн удирдлага, санхүүгийн эрх мэдлийг дээшлүүлж нутгийн удирдлагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй хүнд сурталгүй болгож иргэдийн санал санаачилганд тулгуурласан хяналт хариуцлагын тогтолцоог бий болгоно.
- 6.3. Төсөл, тендер шалгаруулалтыг ил тод, нээлттэй, шударга явуулж тендерийн гүйцэтгэлийн хяналтыг сайруулж, үр өгөөжийг дээшлүүнэ. Тендерийн хууль бус хуйвалдааны шинж чанартай булхайтай үйл ажиллагааг зогсоно.
- 6.4. Аймгийн иргэдийн хурлын төлөөлөгчид, Засаг дарга, удирдах албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах ёс зүйн гэрээ байгуулж, хэрэгжилтийн явцыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилогдсон хөндлөнгийн хяналтын ажлын хэсэг жил бүр дүгнэж, нээлттэй танилцуулдаг журмыг хэрэгжүүлнэ.
- 6.5. Төсвийн зарцуулалт, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг эргэх холбоотойгоор тогтмолжуулна.
- 6.6. Байгалийн баялгаас орж буй орлого, төсөв, тендерийг иргэдээр хэлэлцүүлдэг тогтолцоог бодитой, үр дүнтэй болгоно.
- 6.7. Иргэн нь төрийн удирдах албан тушаалтнаас хариуцлага шаардах “Иргэний асуулга асуух эрх”-ийг бүх шатанд хэрэгжүүлнэ.
- 6.8. Орон нутгийн эрх мэдэл, төсвийн боломжуудыг нээлттэй болгоно. Тусгай зөвшөөрөл болон төсөв хуваарилалтын эрх мэдлийг нэг удирдлагад хэт төвлөрүүлэхээс татгалзаж, бүх шатны удирдлага, төрийн албан хаагчдын эрх, үүрэг, хариуцлагын тэгш боломжийг хангана.
- 6.9. Захиргааны өрөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоо, хяналтын боломжуудыг бодитоор хэрэгжүүлнэ.
- 6.10. Дорнод нутгийн хөгжлийн бодлого, хэтийн төлөвлөлтийг орчин үеийн шаардлага, нийгмийн эрэлтэд нийцүүлэн дахин боловсруулж, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг зохистой, оновчтой бурдүүлж, орон нутаг, бүсийн онцлог, давуу тал, боломж, иргэний оролцоо, итгэл үнэмшилд түшиглэж эрчимтэй хөгжих “Жишиг Дорнод” хөгжлийн аяныг өрнүүлнэ.
- 6.11. Төр засгийн бүх шатны ажлын хариуцлага, эцсийн үр дүнг тухайн сум, багт иргэний амьжиргаа, орлогын өсөлтөөр тооцдог нэгдмэл зарчмыг мөрдөнө.
- 6.12. Төрийн бүх шатны албан хаагчдыг улс төрийн нөлөөлөл, дарамтаас ангид байх, бүтээлч, санаачилгатай, тогтвортой ажиллах, цалин хөлс, нийгмийн хамгааллын тэгш баталгаагаар хангагдах, мерит зарчмаар ахиж дэвших эрх зүйн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллана.

- 6.13. Хүний хөгжил, боловсролыг тэргүүлэх зорилт болгож, нийгмийн оюун санааны нөөц, орон нутагт бий болгосон үнэт зүйл, стандарт, технологийг дэмжиж түгээх, залуучуудыг дэлхийн тэргүүлэх орнуудад сургах ажлыг бүх талаар дэмжинэ.
- 6.14. Дорнодын хөгжлийн тэргүүлэх зорилтыг ХАА, байгалийн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглүүлж, газар тариалан, мал аж ахуйн уламжлал, бодит нөөц боломжид тулгуурласан үндэсний онцлогтой стандарт, технологийг бий болгох замаар цогц бодлого хэрэгжүүлнэ. Дорнод бүс нутагт зохицсон ХАА-г хөгжүүлэх эрдэм шинжилгээ, судлагаа, технологи, мэдээллийн суурь санг бүрдүүлж хөгжүүлнэ.
- 6.15. Шүүгч, прокурор, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байлыг хууль зүй болон зохион байгуулалтаар баталгаажуулахыг дэмжиж ажиллана.
- 6.16. Хуулийн аль нэг шатанд гарсан иргэнд тэгш бус хандсан, ашиг сонирхлын зөрчил гаргасан тохиолдлыг таслан зогсоох олон нийтийн шударга шаардлагыг дэмжиж ажиллана.
- 6.17. Шүүхийн шинжилгээ, шинжээчийн хараат бус үйл ажиллагаа, мэргэжлийн өрчныг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- 6.18. Хууль, шүүхийн байгууллагын албан тушаалтны ёс зүй, зан хариуцаанд тавих олон нийтийн хяналтын тогтолцоог сайжруулахад санаачилгатай ажиллана.
- 6.19. Цахим орчинд хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, байгууллага, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлж, төр засгийн бүх шатанд хууль хэрэгжүүлэх сахилга, хариуцлагыг өндөржүүлнэ.
- 6.20. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх үйл ажиллагааг дэмжинэ.
- 6.21. Хууль сурталчилдах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 6.22. Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүляж, авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах хүрээнд нийгмийн бүх шатанд ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга ёсны тогтолцоог эрхэмлэсэн соёлыг хэвшүүлэхэд онцгой анхаарна.
- 6.23. Төр, түүний бодлого, үйл ажиллагаа нь эрх баригч нам болон парламент, засгийг бүрдүүлсэн олонхийн эрх ашигт хэт захираачаа бус улс орны хөгжлийн үзэл баримтлал, арга замыг тодорхойлж, чиглүүлэн зохицуулах гол институцийн үүргээ биелүүлэхэд нэгдмэл байх жишигийг бүх шатанд эрхэмлэж ажиллана.
- 6.24. Гэрээгээр гүйцэтгүүлж болох чиг үүргүүдийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлнэ. Нөхөрлөл хоршоо төрийн бус байгууллагуудыг бүх талаар дэмжиж ажиллана.
- 6.25. Тусгай сангруудын үйл ажиллагааг үндэсний үйлдвэрлэлийг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд шилжүүлэх.
- 6.26. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, цалин урамшууллыг тэдний бие даасан, бүтээлч үйл ажиллагааг дээшлүүлэх гол хөшүүрэг болгож ажиллана.
- 6.27. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог шинэчилэхэд хүчин чармайлт гаргана.
- 6.28. Засаг захиргаа, түүний нэгжийн тухай, Төсвийн тухай болон бусад холбогдох хууль эрх зүйд өөрчлөлтийг хийж, орон нутаг бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн өмч, татварын тогтолцоо бүхий санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлэхийг дэмжинэ.
- 6.29. Орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг дэмждэг Орон нутгийн хөгжлийн санг төсвийн хөрөнгөөс гадна олон хэлбэрт эх үүсвэрээс бүрдүүлэх хууль эрх зүйн орчныг бий болгож, санг захиран зарцуулах эрхийг иргэдийн төлөөллийн байгууллагын оролцоотой хэрэгжүүлэхийг дэмжинэ.

- 6.30. Төрийн анхан шатны нэгж багийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах зорилгоор төсөв санхүүгийн эрх мэдлийг дээшлүүлнэ.
- 6.31. Байгалийн баялгаас улсын төсөвт орж байгаа орлогын 30-иос доошгүй хувийг орон нутагт нь шууд хуваарилдаг тогтолцоог бүрдүүлэхийг дэмжинэ.
- 6.32. Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ.
- 6.33. Орон нутагт инновацийн сантай байх хөтөлбөр боловсруулан баталж, мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгийн аж ахуйд сууринсан орон нутгийн онцлог брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлэх судалгаа, хөгжүүлэлтийн зардлыг тус сангаас санхүүжүүлэхийг дэмжинэ.
- 6.34. Бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлж, цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд Халхгол, Мэнэн, Чойбалсан, Баян Уул сумдын улсын хил хамгаалалтын холбоо, мэдээллийн сүлжээний шинэчлэл, мөн улсын хил хамгаалалтын болон тусгай зориулалтын авто техникийн шинэчлэл, хил хамгаалалтын зориулалттай инженерийн байгууламж, хилийн отряд, застав, харуул, боомтын барилга байгууламж, дэд бүтцийн шинэчлэл, хилчдийн нийгмийн хамгаалал зэрэг төлөвлөгдсөн хөтөлбөрүүдийг бус нутагт хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхэд санаачилга гаргана.
- 6.35. Орон нутгийн гамшигаас хамгаалах чадавхыг эрс нэмэгдүүлж, бус нутгийн гамшгийн эрсдэлийн түвшинг бүрэн тодорхойлж, эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа бусад чиглэлд шаардлагатай байгаа арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 6.36. Нийтийг хамарсан гамшигт өртөгчдөд үзүүлэх халамжийн тусламж, үйлчилгээг бий болгоно.
- 6.37. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр орон нутагт оногдох орлогыг нэмэгдүүлэх, уул уурхайн бусад нэгжийн татварын орлого, нийгмийн хариуцлага, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгуулж, олон нийтийн хяналт, оролцоотойгоор зарцуулах асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 6.38. Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос, ашигт малтмалын компанийд ажиллаж буй Монгол ажилчдын эрх ашиг, орчин нөхцөл цалин хөлс, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх ажилд санаачилга гаргана.